



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№149 /363/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.23

Цаг үе, үйл явдал

“АХМАДЫН БОЛОН АЛБА ХААГЧДЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН БАРИЛГЫН ЯВЦ 75 ХУВЬТАЙ БАЙНА



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр тэргүүтэй албаныхан БХЯ-ны “Ахмадын болон алба хаагчдын хөгжлийн төв”-ийн барилгын явцтай танилцлаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр барилгын ажлыг гүйцэтгэж буй инженерүүдэд хандаж хэлэхдээ “Бусад яамдуудаас анх удаа БХЯ нь ахмадуудад зориулсан цогц төвтэй болох гэж байна. Манай салбарын ахмадуудын хүлээлт ч тун өндөр байгаа. Тиймээс олон хүний нийгмийн асуудлыг шийдэх, сэтгэл санаанд нь нийцсэн барилга болгох үүднээс та бүхэн сэтгэлээ шингээж ажиллаарай” гэсэн юм.

Харин барилгын гүйцэтгэгч компани болох “Хөх бүрдийн эх” ХХК-ний инженерүүд хэлэхдээ “Бид барилгыг ирэх 12 дугаар сарын



31-ний өдөр гэхэд БХЯ-нд хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Хэдий барилгын материалын үнийн өсөлт, олдоцтой холбогдсон асуудлуудтай тулгарч байгаа ч манай залуус тогтоосон хугацаанд барилгыг чанарын өндөр түвшинд

барьж, хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. “Ахмадын болон алба хаагчдын хөгжлийн төв”-ийн гадна тал нь шилэн фасадтай байх бөгөөд доороо автомашины зогсоолтой, эргэн тойрондоо хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбайтайгаас гадна

ресторан, үйлчилгээний төвүүд байрлахаар зураг төсөл нь хийгдсэн” гэсэн юм.

Нийт 6450 м2 талбай бүхий найман давхар тус барилгын ажил одоогийн байдлаар 75 хувьтай явагдаж байгаа аж.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	🌧️ 5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.202	3.209
EUR 🇪🇺	3.215	3.240
CNY 🇨🇳	468	473
RUB 🇷🇺	49.50	50.10
JPY 🇯🇵	23.40	23.80
KRW 🇰🇷	2.38	2.41

ЗУРХАЙ



2022.08.23 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ХОЁР ХАР ШАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.58-19.52

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал: Гал

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах шинэ гэр ба байр авах, хараал жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу.

Хол газраар яваар одогсод зүүн урд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 599,124,406

Эдгэрсэн

Нийт: 573,111,944

Нас барсан

Нийт: 6,466,793

Цаг үе, үйл явдал

“ДӨЛ” ТЭМЦЭЭНИЙ ОРОЛЦОГЧДОД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



өдөрлөгийг нээж хэлсэн үгэндээ:
Хурд, хүч, авхаалж самбаагаараа онцгойрч цогцолбор тэмцээний сүүлчийн шатанд шалгарсан сурагч, багш, дасгалжуулагч та бүхэнд баяр хүргэе. Манай улс өргөн уудам газар нутаг, баялаг түүхтэй эх орон. Тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулж, төрж өссөн нутаг ус, газар шороогоо хайрлах эх оронч үзлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд БХЯ-наас “Дөл” цэрэгжилтийн-спортын тэмцээнийг 1984 оноос эхлэн ЕБС-ийн сурагчдын дунд

уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Энэ удаагийн тэмцээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй гэдгээрээ онцлогтой болж байна. Эх орноо батлан хамгаалагчдын залгамж халаа болж, үеийн залуусаа манлайлсан, нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой охид, хөвгүүддээ болон сургагч багш дасгалжуулагч та бүхэнд нөр их хүч, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж амжилт гаргахыг хүсэн өрөөе” гэв. Мөн өдөрлөгийн хүрээнд ЦДБЭЧ-ын хамт олон “Цэрэг-Эх” оронч сэдэвт уран бүтээлийн тоглолтоо толилуулж, Зэвсэгт хүчний 016, 120, 311, 326 дугаар нэгтгэл, ангиуд байлдааны техникийн үзэсгэлэн, Зэвсэгт хүчний 015, 084 дүгээр ангиуд буудлагын зэвсгийн үзэсгэлэнгээ дэлгэж олны хүртээл болголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” тэмцээний сүүлийн шатанд шалгарсан аймаг, нийслэл, дүүргийн сурагчдад, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг

сурталчлах өдөрлөгийн арга хэмжээг өчигдөр Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зохион байгууллаа. Өдөрлөгт Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа


тэргүүтэй БХЯ, ЗХЖШ, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын удирдлага, аймаг, дүүргүүдийн цэрэг-спортын шилдэг тамирчин сурагчид оролцсон юм.

Бригадын генерал Д.Ганхуяг



Цахим шууданд

БАЯРЛАЖ, ТАЛАРХСАН СЭТГЭЛЭЭ ТАЛАРХЛЫН МОДОНДОО ТЭМДЭГЛЭН ҮЛДЭЭДЭГ АНГИ



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

“Танд талархъя” аянг зохион байгуулж байна.

Өнгөрсөн 17-ний өдрөөс эхэлсэн тус аян сарын хугацаанд үргэлжилнэ. Нийт 5 талархлын модыг хийж штаб, цэргийн гал тогоо, салбаруудад байрлуулснаар ажилтан, алба хаагчид талархсан сэтгэлийн үгээ уг модон дээр нааж бусдадаа дамжуулан хүргэх боломжтой юм. **Хошууч Ө.Нарантуяа**

НИЙТ НУТГИЙН 60 ГАРУЙ ХУВЬД ХУР ТУНАДАС ОРЖЭЭ



нутгаар 20.1-50.0 мм, Булганы Дашинчилэн, Хангал, Сэлэнгэ, Төвийн Баян-Өнжүүл, Эрдэнэ, Баян, Дундговийн Адаацаг, Хэнтийн Дэлгэрхаанд 50.1-86.9мм оржээ.

Харин Өмнөговийн зарим, Говь-Алтай Баянхонгор, Дорноговийн зарим сумдын нутгаар бороо ороогүй. Орсон хур тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулбал ихэнх нутагт дунджийн орчим ба түүнээс ахиу, говийн нутгийн зарим хэсгээр дунджаас бага байна хэмээн ЦУОШГ-аас мэдээлэв.

Эх сурвалж: IKON.mn

Фото агшин



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)